



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/41

Мандалговь

“Сургуулийн барилгын засварын ажлын
/Дундговь, Хулд сум/-ын гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сургуулийн барилгын засварын ажил /Дундговь, Хулд сум/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Нэргүй (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга)

Гишүүд: Ц.Эрдэнээ (Иргэний төлөөлөл)
Д.Даариймаа (Аймгийн Засаг даргын Тамгын
Газар Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод
аудитын хэлтсийн мэргэжилтэн)
Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын ХАА
хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Нэргүй)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060169